


ДОТООД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2023/01/23-2023/01/27

ТОП 20 индекс



ХАМГИЙН ИХ ДҮНГЭЭР АРИЛЖИГДСАН

Голомт Банк	3,832,918,910
Монголын хөрөнгийн Бирж	443,345,945
АПУ	428,510,668
Ард санхүүгийн нэгдэл	332,858,412
Эрдэнэ ресурс девелопмент	103,117,655

ХАМГИЙН ИХ ӨСӨЛТТЭЙ

	Үнийн дүн	Өсөлт
Монгол Керамик	1,259,750	35.14%
Жидакс	189,748	31.77%
Гонир	13,225	15.00%
Хархорин	64,400	15.00%
Глобал Монголиа Холдинг	49,991	15.00%

ХАМГИЙН ИХ БУУРАЛТТАЙ

	Үнийн дүн	Бууралт
Увс Чацаргана	108,360	-13.85%
Түшиг Уул	55,250	-13.33%
Жуулчин Дюти Фрий	1,241,100	-10.31%
Гутал	2,102,100	-9.08%
Эрдэнэс сольюшинс	7,873,432	-8.00%

МХБ-ын Top 20 индекс өнгөрсөн долоон хоногт 37,867 нэгжид хүрч өнгөрсөн 7 хоногоос 0.55%-иар өссөн байна. Хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ 6.97 их наяд ₮ хүрээд байна.

Өнгөрсөн долоон хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 75 компанийн 6.38 тэрбум ₮-ийн 10.35 сая ширхэг үнэт цаас арилжаалагдсан ба арилжааны дүн 2.28 дахин өссөн байна.

Үүнээс 340.2 сая ₮-ийн ХБҮЦ, 247 сая ₮-ийн компанийн бонд, 37.2 сая ₮-ийн хамтын хөрөнгө оруулалтын сан, 5.75 тэрбум ₮-ийн хувьцааны арилжаа хийгдсэн байна.

Хамгийн их дүнгээр арилжаалагдсан 5 хувьцаа өнгөрсөн 7 хоногийн хувьцааны хоёрдогч арилжааны 89%-ийг эзэлж байна. Өнгөрсөн долоон хоногт 2022 оны санхүүгийн тайлангаа олон нийтэд танилцуулсан Голомт Банкны хувьцаа хамгийн өндөр буюу 3.8 тэрбум ₮ өөр арилжаалагдсан байна. Мөн Монголын хөрөнгийн бирж хоёр долоон хоног дараалан хамгийн өндөр дүнгээр арилжаалагдсан хувьцааны ангилалд багтлаа.

Өнгөрсөн долоон хоногт Монгол Керамик ХК 35.14%-ийн өсөлт үзүүлсэн боловч арилжааны дүн харьцангуй бага байна. Арилжааны өсөлтийн хувиар тэргүүлсэн хувьцаануудын арилжааны дүн нь харьцангуй бага байгаа ба хөрвөх чадвар хангалтгүй байна.

Өнгөрсөн 7 хоногт Увс чацаргана ХК хамгийн өндөр хувь хэмжээгээр буюу 13.85%-ийн уналт үзүүлсэн байна. Уналтын хувь хэмжээгээр тэргүүлсэн хувьцаанууд ч мөн адил арилжааны дүн бага байна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

+976 75100575

info@rhinosinvest.mn

www.rhinosinvest.mn

ДОТООД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2023/01/23-2023/01/27

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

СЭНДЛИ ББСБ ХК-ИЙН 8.5 ТЭРБУМ ₮-ИЙН НЭЭЛТТЭЙ БОНД ЗАХИАЛГЫН ЭХНИЙ ӨДӨРӨӨ 1 ЦАГИЙН ДОТОР АМЖИЛТТАЙ ХААГДЛАА.

- Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй “Сэндли ББСБ” ХК нь 8.5 тэрбум ₮-ийн нээлттэй бонд гаргах зөвшөөрлөө Санхүүгийн зохицуулах хорооны 2023/01/13-ны өдрийн хурлаар авч 2023/01/25-2023/01/31-ны хооронд захиалга авахаар болсон. 2023/01/25-ны өдөр захиалга эхэлмэгц **1 цагийн дотор** 8.5 тэрбум ₮-ийн захиалга дүүрч хаагдсан байна.

Sendly RHINOS Investment

8.5
ТЭРБУМ ₮

100%

Амжилттай хаагдлаа

Хөрөнгө оруулагчдадаа баярлалаа

- Энэхүү бүтээгдэхүүн нь сүүлийн 10 жилийн хамгийн өндөр өгөөжтэй нээлттэй бонд буюу **19.2%**-ийн өгөөжтэй, Хугацааны дундуур арилжих боломжтой буюу **Put option** нөхцөлтэй бүтээгдэхүүн байв.

ХАРИЛЦАГЧ ТА ӨНДӨР ӨГӨӨЖТЭЙ ЭРСДЭЛ БАГА БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАЛААР МЭДЭЭЛЭЛ АВАХЫГ ХҮСВЭЛ ДООРХ УТСААР ХОЛБОГДОНО УУ

2022 ОНД ТӨРИЙН БАНК БОЛОН ГОЛОМТ БАНК НИЙТ 196.7 ТЭРБУМ ₮-ИЙН АШИГТАЙ ГАРЛАА

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй Төрийн банк болон Голомт банк 2022 оны санхүүгийн тайлангаа танилцууллаа.



Төрийн банк 2021 онд 45.7 тэрбум ₮-ийн ашигтай ажилласан бол 2022 онд 96.2 тэрбум ₮-ийн ашигтай ажиллаж 110%-ийн өсөлт үзүүллээ.



Голомт банк 2021 онд 22.1 тэрбум ₮-ийн ашигтай ажилласан бол 2022 онд 100.5 тэрбум ₮-ийн ашигтай ажиллаж 4.5 дахин өссөн байна. Монголын хөрөнгийн биржд бүртгэлтэй системийн 2 банкны 2022 оны ашиг нийтдээ 196.7 тэрбум ₮-т хүрээд байна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

+976 75100575

info@rhinosinvest.mn

www.rhinosinvest.mn

